



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/099/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: <a href="mailto:chantsaldulamp@audit.gov.mn">chantsaldulamp@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: <a href="mailto:nyamtsetsegi@audit.gov.mn">nyamtsetsegi@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: <a href="mailto:dabq.audit@gmail.com">dabq.audit@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

УЛААНБААТАР ХОТЫН ХАТУУ ХОГ  
ХАЯГДЛЫН БАЙГУУЛАМЖИЙГ  
ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ  
Б.ЧАНДМАН ТАНАА

2025.02.25 № 07/724  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх” төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлд орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах саналыг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлж ажиллахыг даалгасан байна.

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 03 дугаар тэмдэглэлд Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо, Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт байгуулагдсан Олон улсын стандартад нийцсэн хог дарж булшлах ландфилын байгууламж бүхий төвлөрсөн хогийн цэг, барилга нураалтаас гарсан бетон тоосгоны хаягдлыг хүлээн авч, бутлан ангилж ялгах байгууламжийн цаашдын үйл ажиллагааг явуулах нэгж байгуулах тухай саналыг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Зээлийн хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн е-д “Захиалагч тал нь төсөл хэрэгжүүлж дуусахад шаардлагатай санхүүжилтийг гаргахад чиглэсэн бүхий л нэмэлт арга хэмжээг авах, эсхүл арга хэмжээг авхуулах үүрэгтэй” гэсний дагуу ханшийн зөрүүгээс үүссэн 70,000.00 ам.доллар буюу 280,000.0 мянган төгрөгийн дутуу санхүүжилтийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/1510 тоот захирамжаар хөрөнгө оруулалтын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэж, зарцуулсан байна.

Нийслэлийн засаг даргын тамгын газраас 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 05/7744 дугаар албан бичгээр төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны үйл ажиллагааны төсвийг 391,875.0 мянган төгрөгөөр батлан ирүүлсэн. Тайлант онд ажилтнуудын цалин, нийгмийн даатгал, төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд 355,793.3 мянган төгрөгийг зарцуулж, нийслэлийн орон нутгийн урсгал төсвийн гүйцэтгэлд нэгтгүүлсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно:

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>34,293,232,727.75</b>	<b>45,344,421,940.55</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>106,320,296.65</b>	<b>104,921,676.42</b>
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>106,320,296.65</b>	<b>104,921,676.42</b>
3121	<b>Төгрөг</b>	<b>1,671,732.51</b>	<b>1.07</b>
31210	Төрийн сангийн харилцах	1,671,732.51	1.07
3122	<b>Гадаад валют</b>	<b>104,648,564.14</b>	<b>104,921,675.35</b>
31221	Төрийн сангийн харилцах	104,648,564.14	104,921,675.35
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>34,186,912,431.10</b>	<b>45,239,500,264.13</b>
34600	Урьдчилж гарсан зардал	34,186,912,431.10	45,239,500,264.13
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>34,293,232,727.75</b>	<b>45,344,421,940.55</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,691,731.44</b>	-
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,691,731.44</b>	-
41300	<b>Өглөг</b>	<b>1,691,731.44</b>	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,483,331.44	-
	<b>Бусад өглөг</b>	<b>208,400.00</b>	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	208,400.00	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>34,291,540,996.31</b>	<b>45,344,421,940.55</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>34,291,540,996.31</b>	<b>45,344,421,940.55</b>
512	Хуримтлагдсан үр дүн	34,291,540,996.31	45,344,421,940.55
51210	Өмнөх үеийн үр дүн	14,141,612,764.54	34,291,540,996.31
51220	Тайлант үеийн үр дүн	20,149,928,231.77	11,052,880,944.24
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>34,293,232,727.75</b>	<b>45,344,421,940.55</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>20,271,513,588.46</b>	<b>11,052,587,833.03</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГ</b>	<b>20,271,513,588.46</b>	<b>11,052,587,833.03</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>12,444,957,305.63</b>	<b>6,452,213,424.06</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,444,957,305.63	6,452,213,424.06
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	12,444,957,305.63	6,452,213,424.06
122	Тусламжийн орлого	7,826,556,282.83	4,600,374,408.97
122002	Хандив тусламж /гадаад/	7,826,556,282.83	4,600,374,408.97
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>121,805,998.18</b>	-
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>121,805,998.18</b>	-
210	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>121,805,998.18</b>	-
210101	Үндсэн цалин	108,360,932.60	-
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	13,445,065.58	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>20,149,707,590.28</b>	<b>11,052,587,833.03</b>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>220,641.49</b>	<b>293,111.21</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	220,641.49	293,111.21
5	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>20,149,928,231.77</b>	<b>11,052,880,944.24</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>448,522.00</b>	-
2	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>448,522.00</b>	-
3	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>448,522.00</b>	-
4	Бусад орлого	448,522.00	-
5	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>120,582,788.73</b>	<b>1,691,731.44</b>
6	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>120,582,788.73</b>	<b>1,243,209.44</b>
7	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>107,137,723.15</b>	<b>1,243,209.44</b>
8	Үндсэн цалин	107,137,723.15	1,243,209.44
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,445,065.58	-
10	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>448,522.00</b>
11	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	448,522.00
12	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	448,522.00
13	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(120,134,266.73)</b>	<b>(1,691,731.44)</b>
14	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
15	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>220,641.49</b>	<b>293,111.21</b>
16	<b>Бусад эх үүсвэрээр</b>	<b>220,641.49</b>	<b>293,111.21</b>
17	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	220,641.49	293,111.21
18	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(119,913,625.24)</b>	<b>(1,398,620.23)</b>
19	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>226,233,921.89</b>	<b>106,320,296.65</b>
20	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>106,320,296.65</b>	<b>104,921,676.42</b>

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	<b>14,141,612,764.54</b>	<b>14,141,612,764.54</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		<b>14,141,612,764.54</b>	<b>14,141,612,764.54</b>
Тайлант үеийн үр дүн		20,149,928,231.77	20,149,928,231.77
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>		<b>34,291,540,996.31</b>	<b>34,291,540,996.31</b>
<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>		<b>34,291,540,996.31</b>	<b>34,291,540,996.31</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		<b>34,291,540,996.31</b>	<b>34,291,540,996.31</b>
Тайлант үеийн үр дүн		11,052,880,944.24	11,052,880,944.24
<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	<b>45,344,421,940.55</b>	<b>45,344,421,940.55</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,374,000,000.00</b>	<b>11,053,831,042.47</b>	<b>320,168,957.53</b>	<b>97.2</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,500,000.00</b>	<b>1,243,209.44</b>	<b>10,256,790.56</b>	<b>10.8</b>
<b>БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,500,000.00</b>	<b>1,243,209.44</b>	<b>10,256,790.56</b>	<b>10.8</b>
Үндсэн цалин	1,500,000.00	,243,209.44	256,790.56	<b>82.9</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,000,000.00</b>	-	<b>10,000,000.00</b>	-
Аудитын төлбөр	10,000,000.00	-	10,000,000.00	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ</b>	<b>4,910,000,000.00</b>	<b>4,600,374,408.97</b>	<b>309,625,591.03</b>	<b>93.7</b>
Барилга байгууламж	4,910,000,000.00	4,600,374,408.97	309,625,591.03	93.7
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>6,452,500,000.00</b>	<b>6,452,213,424.06</b>	<b>286,575.94</b>	<b>100.0</b>
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	6,452,500,000.00	6,452,213,424.06	286,575.94	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>11,374,000,000.00</b>	<b>11,052,587,833.03</b>	<b>321,412,166.97</b>	<b>97.2</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>6,452,500,000.00</b>	<b>6,452,213,424.06</b>	<b>286,575.94</b>	<b>100.0</b>
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,452,500,000.00	6,452,213,424.06	286,575.94	100.0
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>4,910,000,000.00</b>	<b>4,600,374,408.97</b>	309,625,591.03	93.7
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	4,910,000,000.00	4,600,374,408.97	309,625,591.03	93.7
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		106,320,296.65		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		104,921,676.42		
Байгууллагын тоо	1	1		100.0
Ажиллагсдын тоо	5	5		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар 1 зөрчилд зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс:			
			Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 159 мэдээллээс хугацаа болоогүй 5 мэдээ, хугацаа хоцроон байршуулсан 11,374,000.0 мянган төгрөгийн 4 мэдээ байгаа нь 97.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оноос зөрчил 15 мэдээгээр буюу 78.5 хувиар буурсан, өмнөх онд хоцроосон мэдээллийг давтан хоцроогоогүй байна.	1	-			1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>